	Э.Энхтөр	Сонгинохайрхан дүүргийн 37 дугаар хорооны Засаг дарга;
	С.Сайхантуяа	Сонгинохайрхан дүүргийн 39 дүгээр хорооны Засаг дарга;
	Д.Саруул-Ирээдүй	Сонгинохайрхан дүүргийн 42 дугаар хорооны Засаг дарга;
	Л.Батдорж	Сонгинохайрхан дүүргийн 43 дугаар хорооны Засаг дарга;
	Б.Сарнайцэцэг	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, тохижилтын санхүүжилт хариуцсан нягтлан бодогч;
	Э.Элбэгбаяр	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын Үндсэн хөрөнгийн нярав;
	Г.Сэр-Од	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн Техник хангамж хариуцсан мэргэжилтэн;
	О.Ган-Өлзий	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн Архивын эрхлэгч;
Нарийн бичгийн дарга:	Ц.Болормаа	"Гранд Макс" ХХК-ийн Захирал.

«ཡིག་ཚང་གི་ཐབས་ལམ་དང་ཕྱག་ཆ་ཚང་བའི་ཞུ་ཡིག»

ཕྱག་ཆ་ཚང་བའི་ཞུ་ཡིག

ཞུ་མཁན་གྱི་མིང་ ..... ཤོག་གྲངས་ ..... ཚུད་

ཞུ་ཡིག་ཐོ་འགོད་ཀྱི་ཨང་ ..... ཚེས་ ..... ལོ་ ..... ཟླ་ ..... ཉིན་

ཞུ་ཡིག་ཐོ་འགོད་པའི་ཡིག་ཚང་ ..... ཚེས་ ..... ལོ་ ..... ཟླ་ ..... ཉིན་

ཞུ་ཡིག་ཐོ་འགོད་པའི་ལས་བྱེད

НИЙСЛЭЛИЙН
“ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 02 өдөр Дугаар А/37 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн боловсролыг дэмжих
чиглэлээр хэрэгжүүлэх ажлын
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.19 дэх заалт, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын ажилтнуудын Эрүүл мэндийн боловсролыг дэмжих, хамгаалах чиглэлээр 2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний хүрээнд зарцуулагдах хөрөнгийг сургалтын зардлаас гаргахыг Санхүү, аж ахуйн хэлтэс (Д.Пүрэвжав)-т зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнаж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Ц.Гүрбадам)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

1725010147
G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 04 дүгээр сарын 02-ны
өдрийн А/... дугаар тушаалын хавсралт

А/37

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ

АЖИЛТНУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ, ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Зардал	Хугацаа	Хамтран хэрэгжүүлэх
1	2	3	4	5	6	7
Нэг.Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд						
1.1	Ажилтнуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, мэдлэг олгох чиглэлээр зөвлөмж, мэдээлэл бэлтгэн Газрын дотоод сүлжээ, мэдээллийн самбарт байршуулах	Долоо хоног бүр зөвлөмж, мэдээллийг бэлтгэн холбогдох талбарт байршуулах	Ажилтнуудын эрүүл мэндийн мэдлэг, боловсрол дээшилнэ	-	II - IV улирал	Захиргааны хэлтэс
1.2	Хорт, муу зуршлаас татгалзах, амьдралын зөв дадалд суралцах нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Нийт ажилтнуудыг хамруулах	Арга хэмжээнд ажилтнуудыг бүрэн хамруулна	Тухай бүр	I- IV улирал	Захиргааны хэлтэс, Залуучуудын хөгжлийн зөвлөл
1.3	“Health education academy”-тай хамтран ажилтнуудын эрүүл мэндэд чиглэсэн сургалт зохион байгуулах	Нийт ажилтнуудыг хамруулах	Эрүүл мэндийн сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна	1.000.000	II - III улирал	Захиргааны хэлтэс, Санхүү, аж ахуйн хэлтэс
1.4	Дэлхийн эрүүл мэндийн өдөр *(мэргэжлийн байгууллагатай хамтран өдөрлөг зохион байгуулах)*-ийг тэмдэглэн өнгөрүүлэх	Нийт ажилтнуудыг хамруулах	Ажилтнуудыг бүрэн хамруулна	-	II улирал	Захиргааны хэлтэс, Санхүү, аж ахуйн хэлтэс
Хоёр.Дасгал, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих ажлын хүрээнд						
2.1	“НХОГ явган алхалтын өдөр”-ийг цэвэр агаар идэвхтэй хөдөлгөөн уриан дор зохион байгуулах	Нийт ажилтнуудыг хамруулах	Хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, явган алхалтыг зохион байгуулсан байна	-	III улирал	Захиргааны хэлтэс, Соёл, спорт хамтлаг залуучуудын зөвлөл
2.2	Ажлын байранд эрүүл амьдрах хэв маягийг дэмжих ажлыг зохион байгуулах	Нийт ажилтнуудыг хамруулах	Ажилтнуудыг эрүүл амьдралын хэв маягт хөтлөн хөдөлмөрлөх явцад бий болсон ядралыг сэргээн, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэн ажилласан байна	-	II - IV улирал	Бүх хэлтсүүд

1	2	3	4	5	6	7
2.3	Ажлын байрны дасгал хөдөлгөөн сэдвийн хүрээнд видео зөвлөмж бэлтгэн, Газрын сайт, дотоод сүлжээнд байршуулан түгээх	Нийт ажилтнуудыг хамруулах	Ажилтнуудын эрүүл мэндийн боловсролыг дэмжин видео зөвлөмжийг Газрын invest.ub.gov.mn вэб сайт, дотоод сүлжээ (НХОГ соёл, спорт)-нд байршуулан цувралаар танилцуулан түгээсэн байна	Тухай бүр	II-IV улирал	Захиргааны хэлтэс, Мэдээллийн технологийн хэлтэс
Гурав.Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг шижилгээнд хамруулах ажлын хүрээнд						
3.1	Ажилтны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор нарийн мэргэжлийн оношилгоо шинжилгээнд хамруулах ажлын зохион байгуулах	Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдаагүй ажилтнуудыг хамруулах	2025 онд нарийн мэргэжлийн оношилгоо шинжилгээнд хамрагдаагүй ажилтнуудын судалгаанд үндэслэн ажилтнуудыг хамруулсан байна	Тухай бүр	I- IV улирал	Захиргааны хэлтэс, Санхүү, аж ахуйн хэлтэс
3.2	Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 521 дүгээр тогтоол. "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу ажилтнуудыг сэтгэцийн эрүүл мэндийн нарийн мэргэжлийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах	Нийт ажилтнуудыг хамруулах	Ажилтнуудыг бүрэн хамруулсан байна	-	II-III улирал	Захиргааны хэлтэс
3.3	Эрүүл мэндийн үзлэг шинжилгээ зохион байгуулсан тухай мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, баяжуулах	Мэдээллийн нэгдсэн сан хөтлөх	Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан ажилласан тухай нэгдсэн мэдээллийн сан баяжуулан ажилласан байна	-	III-IV улирал	Захиргааны хэлтэс
3.4	"Цусны үндэсний төв"-тэй хамтран цус хандивлах сайн дурын ажлыг зохион байгуулах	Ажилтнуудын 30 хувиас дээшгүй хувийг хамруулах	Ажилтнуудад холбогдох мэдээллийг хүргэн, цусаа өгснөөр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх анхан шатны шинжилгээнд хамрагдах боломж бүрдэнэ	-	III улирал	Захиргааны хэлтэс
3.5	Төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнан ажиллах	Хагас жил, жилийн эцсийн байдлаар биелэлтийг тайлагнах	Төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн Газрын даргад танилцуулан ажилласан байна	-	II- IV улирал	Захиргааны хэлтэс

----oOo----

«مسئول دار المحفوظات الرسمية للمملكة»
المملكة المغربية، الرباط، ص.ب ٥٠٠٠٠، الهاتف ٠٥٣٧٧٢٩٢٩٢

رقم ٢٥٥ بتاريخ ٢٠٢٥/٠٩/٠٨

إلى السيد مدير مطبعة الأمنية
بالرباط

الموضوع: طلب عرض أثمان

سيدي المدير،

يشرفني أن أطلب منكم تقديم عرض أثمان لطبع ٥٠٠ نسخة من كتاب «مسئول دار المحفوظات الرسمية للمملكة»، من تأليف السيد عبد الرحيم بنحادة، وذلك وفق المواصفات التالية:

- الحجم: ١٧ × ٢٤ سم؛
- عدد الصفحات: ٢٠٨ صفحات؛
- الغلاف: مقوى مطبوع بالألوان؛
- الورق الداخلي: ورق أبيض من الحجم ١٠٠ غرام؛
- التجليد: خياطة بالخيط وتجليد متين؛
- الآجال: تسليم النسخ في أجل أقصاه ٢٥ يوما من تاريخ إرسال الطلب.

يرجى من سيادتكم التكرم بإرسال عرضكم في أجل أقصاه ١٠ أيام من تاريخ توصلكم بهذه الرسالة.

وتقبلوا، سيدي المدير، فائق عبارات التقدير والاحترام.

المسئول عن دار المحفوظات الرسمية

عبد الرحيم بنحادة

1725010003

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 08 өдөр Дугаар А/38 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны А/338 дугаар захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэг, 2026 оны ОН2512001969002 дугаартай ажлын гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Захиалагчийн хяналт тавих тухай" А/338 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 4 дүгээрт заасан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Багц:2 Баянзүрх дүүрэг, 35 дугаар хороо, Нийгмийн хамгааллын тусгай төвийн өргөтгөл буюу сургалт хүмүүжлийн төвийн байрны гал тогооны тоног төхөөрөмж хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн архивын ажилтанд хүлээлгэн өгөхийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Э.Элдэв-Очир)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга захиалагчийн хяналтын хэлтэс (Б.Ганзориг)-т даалгасугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

1725010153

Document3

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны
өдрийн А/38 дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Ц.Адъяа	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн Ахлах нягтлан бодогч;
Гишүүд:	Л.Бат-Ололт	Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн Аж ахуйн албаны дарга;
	П.Эрдэнэ-Маргад	“Чиглэл” ХХК-ийн Тендерийн менежер;
	О.Ган-Өлзий	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн Архивын эрхлэгч;
Нарийн бичгийн дарга:	Э.Элдэв-Очир	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Ус хангамж, ариутгах татуургын хяналтын инженер.

«ئەسەن ناس ھېيئەتىنىڭ ئومۇمىي ئىشخانىسى»
ئەسەن ناس ھېيئەتىنىڭ ئومۇمىي ئىشخانىسى

ئىشخانا مۇدىرى: ئەسەن ناس

نومۇر: ۲۰۲۵/۱۴

ئەسەن ناس ھېيئەتىنىڭ ئومۇمىي ئىشخانىسى

ھۆرمەتلىك ئەسەن ناس ھېيئەتىنىڭ رەئىسى ۋە ئەزالىرى،

ئەسەن ناس ھېيئەتىنىڭ ئومۇمىي يىغىنى ۲۰۲۵-يىلى ۱۰-ئاينىڭ ۲۰-كۈنى سائەت ۰۹:۰۰ دە ئەسەن ناس ھېيئەتىنىڭ ئومۇمىي يىغىن زالىدا ئېچىلىدىغانلىقى توغرىسىدا ئۇقتۇرۇلىدۇ. يىغىنغا قاتنىشىش ھوقۇقىغا ئىگە ئەزالار ۲۰۲۵-يىلى ۹-ئاينىڭ ۳۰-كۈنىگىچە ئەسەن ناس ھېيئەتىنىڭ ئومۇمىي ئىشخانىسىغا ئېلخەت ياكى قەغەز خەت ئارقىلىق ئۆز ۋەكىللىرىنى تىزىملىتىشى كېرەك.

يىغىندا مۇھاكىمە قىلىنىدىغان ئاساسلىق مەسىلىلەر تۆۋەندىكىلەرنى ئۆز ئىچىگە ئالىدۇ: ۱) ۲۰۲۴-يىلىق مالىيە ھېسابىنى تەستىقلاش؛ ۲) ۲۰۲۵-يىلىق بۈدجېت پىلانىنى ماقۇللاش؛ ۳) ئەسەن ناس ھېيئەتىنىڭ ئۇستاز ۋە ئىشچىلىرىنى راغبەتلەندۈرۈش پۇلىنى تارقىتىش؛ ۴) ئەسەن ناس ھېيئەتىنىڭ ئۇستازلىرىنى ئالماشتۇرۇش ۋە ئۆستۈرۈش پروگراممىسىنى ئىلگىرى سۈرۈش؛ ۵) ئەسەن ناس ھېيئەتىنىڭ ئۇستازلىرىنى ئالماشتۇرۇش ۋە ئۆستۈرۈش پروگراممىسىنى ئىلگىرى سۈرۈش.

ئەسەن ناس ھېيئەتىنىڭ ئەزالىرى ئۆز ۋاقتىدا يىغىنغا قاتنىشىشنى ئۈمىد قىلىمىز.

ھۆرمەت بىلەن،

ئەسەن ناس ھېيئەتىنىڭ ئومۇمىي ئىشخانىسى

1725010006

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 03 өдөр Дугаар А/39 Улаанбаатар хот

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэг, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны А/337 дугаар захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/29 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Үнэлгээний хорооны бүрэлдэхүүний гишүүн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтсийн Байгаль орчин болон агаар, орчны бохирдлыг бууруулах бодлого хариуцсан мэргэжилтэн Ж.Энхтөгсмаа нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажиллах боломжгүй болсон тул гишүүнээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн санхүүжилт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, төлөвлөлт хариуцсан Ахлах мэргэжилтэн Э.Бямбасүрэнг болгон өөрчилсүгэй.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга захиалагчийн хяналтын хэлтэс (Б.Ганзориг)-т даалгасугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

1725010155

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

1725010007

د ولسمشر د دفتر د ټولنیزو چارو د مرستیال دفتر
د ټیلیفون شمیره: 0796196722
د ولسمشر د دفتر د مرستیال دفتر

ګ.ش. ۹۵

ښاغلی ډاکټر عبدالله عبدالله
د افغانستان اسلامي جمهوریت د ولسمشر د دفتر د مرستیال
د ولسمشر د دفتر د ټولنیزو چارو د مرستیال دفتر

ښاغلی ډاکټر عبدالله عبدالله
د افغانستان اسلامي جمهوریت د ولسمشر د دفتر د مرستیال
د ولسمشر د دفتر د ټولنیزو چارو د مرستیال دفتر

ګ.ش. ۹۵

د ولسمشر د دفتر د ټولنیزو چارو د مرستیال دفتر

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 13 өдөр Дугаар А/40 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны А/20 дугаар захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэг, 2025 оны ОН2512001882001 Багц-1 дугаартай ажлын гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/20 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 5 дугаарт заасан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Улаанбаатар хот, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн архивын ажилтанд хүлээлгэн өгөхийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Дамдинбазар)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээллийн технологийн хэлтэс (С.Соёмбо)-т даалгасугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

1725010161

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 04 дүгээр сарын 13-ны
өдрийн А/140 дүгээр тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Г.Сэр-Од	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн Техник хангамж хариуцсан мэргэжилтэн;
Гишүүд:	С.Ариунтунгалаг	Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны Салбар зөвлөлийн гишүүн байгууллагын асуудал Хариуцсан хуулийн зөвлөх ажилтан;
	М.Бат-Очир	Нийслэлийн хяналт шалгалтын газар Улсын байцаагч;
	С.Анарбаяр	Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны техникийн асуудал хариуцсан ажилтан
	Б.Билэгжаргал	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн Сүлжээ хариуцсан мэргэжилтэн;
	О.Ган-Өлзий	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн Архивын эрхлэгч;
Нарийн бичгийн дарга:	Б.Дамдинбазар	"Про пэйнтинг" ХХК-ийн захирал.

1725010011

ᠪᠠᠭᠤᠰᠢᠯᠠᠭᠴᠢ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠯᠠᠭᠠ ᠶᠡᠬᠡ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠲᠡᠮᠳᠡᠭᠯᠡᠯ

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 15 өдөр Дугаар А/41 Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгож,
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2023 оны А/570 дугаар захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, БЗДХААА/202308126-1 дугаартай ажлын гэрээ, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2026 оны 03/644 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2023 оны А/570 дугаар захирамжийн хавсралтаар батлагдан төсөл, арга хэмжээний жагсаалтын 3 дугаар ажил, БЗДХААА/202308126-1 дугаартай ажлын гэрээний дагуу Баянзүрх дүүргийн камержуулалтын ажлыг хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар батлалсугай.

2.Холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн архивын ажилтанд хүлээлгэн өгөхийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Батбаяр)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга захиалагчийн хяналтын хэлтэс (Б.Ганзориг)-т даалгасугай.

4.Энэ тушаал гарснаар Газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/133, 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн "Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай" А/32 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

1725010167

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 04 дүгээр сарын 15. -ны
өдрийн А/41 дүгээр тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	С.Соёмбо	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга;
Гишүүд:	С.Чанагнянгар	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт, нийтийн Аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг Түр орлон гүйцэтгэгч;
	А.Даваажав	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг Түр орлон гүйцэтгэгч;
	Б.Ганболд	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, Удирдлагын хэлтсийн Хөрөнгө хариуцсан нягтлан бодогч;
	Б.Алтанзаяа	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Ахлах мэргэжилтэн;
	Д.Баттөр	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Телекамерын хяналтын Дэд төвийн дарга;
	С.Мөнхбаатар	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Телекамерын хяналтын дэд төвийн Ерөнхий инженер;
	О.Ган-Өлзий	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын" Захиргааны хэлтсийн архивын эрхлэгч;
	Н.Нямдорж	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Цахилгааны хяналтын инженер;

	Д.Ариунболд	“Арбэл Алтай” ХХК-ийн инженер;
	Л.Орхон	“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Зүүн түгээх төвийн ашиглалтын инженер;
	М.Алтангэрэл	“Замын хөдөлгөөн удирдлагын төв” ОНӨТҮГ-ын Телекамерын хяналтын хэлтсийн Төлөвлөлт, хяналтын инженер;
	У.Одгэрэл	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Холбооны хяналтын инженер;
Нарийн бичгийн дарга:	Б.Батбаяр	“Бодь электроникс” ХХК-ийн Төслийн удирдлагын газрын Захирал.

1725010014

ගණුදෙනුකරු ෆ.ඉ.

ඔබගේ ඉල්ලීම පරිදි ඔබගේ ණය ගිණුම් අංක ෂ/ණ ෂෂෂ-ෂෂෂෂෂෂ-ෂෂෂ හි ඇති ණය ශේෂය ඉවත් කිරීම සඳහා ඔබ විසින් ඉදිරිපත් කරන ලද ඉල්ලීම අනුව ඔබගේ ණය ගිණුම් අංක ෂ/ණ ෂෂෂ-ෂෂෂෂෂෂ-ෂෂෂ හි ඇති ණය ශේෂය රු. ෂෂ,ෂෂෂ.ෂෂ (රුපියල් ෂෂ,ෂෂෂ.ෂෂ)

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 15 өдөр Дугаар А/42 Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, мөн хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэг, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны А/531 дүгээр захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/531 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Туяажаргал)-д даалгасугай.

3.Төсөл, арга хэмжээний хүрээнд холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Ариунцэцэг)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга захиалагчийн хяналтын хэлтэс (Б.Ганзориг)-т даалгасугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

1725010163

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/142 дугаар тушаалын хавсралт

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Б.Туяажаргал	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Барилгын хяналтын инженер;
Гишүүд:	Б.Өнөрбилэг	НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын газрын Мэдээллийн ил тод байдал хариуцсан мэргэжилтэн;
	Б.Билэгжаргал	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн Сүлжээ хариуцсан мэргэжилтэн;
	Р.Дуламжав	Нийгмийн хөгжлийн "Ертөнц" ТББ-ын тэргүүн;
Нарийн бичгийн дарга:	Г.Ариунцэцэг	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Зураг төслийн хяналтын хэлтсийн Зураг төслийн хяналтын инженер.

«ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠰᠢᠯᠵᠢᠶᠡᠬᠦ ᠬᠣᠤᠰᠠᠨ ᠤ ᠬᠤᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲ ᠥᠭᠴᠦ᠂ ᠵᠠᠰᠠᠭ ᠵᠠᠷᠯᠢᠭ ᠤᠭᠰᠠᠷᠬᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠤᠤᠯᠢ»

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠰᠢᠯᠵᠢᠶᠡᠬᠦ ᠬᠣᠤᠰᠠᠨ ᠤ ᠬᠤᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲ ᠥᠭᠴᠦ᠂ ᠵᠠᠰᠠᠭ ᠵᠠᠷᠯᠢᠭ ᠤᠭᠰᠠᠷᠬᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠤᠤᠯᠢ

ᠵᠠᠰᠠᠭ ᠵᠠᠷᠯᠢᠭ ᠤᠭᠰᠠᠷᠬᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠤᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲ ᠥᠭᠬᠡᠬᠦ ᠵᠠᠭᠪᠤᠷ᠂

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 15 өдөр Дугаар А/43 Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, мөн хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэг, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны А/536 дугаар захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/536 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга (Ц.Гүрбадам)-д даалгасугай.

3.Төсөл, арга хэмжээний хүрээнд холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Энхчимэг)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга захиалагчийн хяналтын хэлтэс (Б.Ганзориг)-т даалгасугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

1725010172

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/143... дугаар тушаалын хавсралт

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Ц.Гүрбадам	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн дарга;
Гишүүд:	Э.Гэрэлт-Од	НЗДТГ-ын Нийслэлийн Бодлого, Төлөвлөлтийн газрын Хот байгуулалт, газар зохион байгуулалтын бодлого, төлөвлөлт хариуцсан Ахлах мэргэжилтэн;
	Т.Энхтөгөлдөр	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Зураг төслийн хяналтын хэлтсийн Зураг төслийн хяналтын инженер;
	Р.Дуламжав	Нийгмийн хөгжлийн ''Ертөнц" ТББ-ын тэргүүн;
Нарийн бичгийн дарга:	Г.Энхчимэг	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Төлөвлөлт судалгааны хэлтсийн Төлөвлөлт судалгааны мэргэжилтэн.

«مصنع الصيدلة المركزي للجماهيرية العظمى»

ص.ب ٠٠٠

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 15 өдөр Дугаар А/44 Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, мөн хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэг, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны А/540 дүгээр захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/540 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Лхагважав)-д даалгасугай.

3.Төсөл, арга хэмжээний хүрээнд холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (О.Мөнгөнтуяа)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга захиалагчийн хяналтын хэлтэс (Б.Ганзориг)-т даалгасугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

3725010173

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/.... дүгээр тушаалын хавсралт

А/44

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Б.Лхагважав	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Зураг төслийн хяналтын хэлтсийн дарга;
Гишүүд:	Б.Батцэцэг	НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн Агуулга, хөтөлбөрийн хөгжүүлэлт хариуцсан ажилтан;
	Ч.Баярхүү	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Барилгын хяналтын инженер;
	Р.Дуламжав	Нийгмийн хөгжлийн ‘’Ертөнц” ТББ-ын тэргүүн;
Нарийн бичгийн дарга:	О.Мөнгөнтуяа	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Төлөвлөлт судалгааны хэлтсийн Төлөвлөлт судалгааны мэргэжилтэн.

«مصنع الأدوية الحديثة للصناعات الدوائية»
ش.م.م - ص.ب ٢٠٤٥ - الرباط

رقم ٢٠٢٢/٠٣/١٥

إلى السيد مدير مكتب الدراسات والاستشارات الفنية

الموضوع: طلب عرض أسعار لتوريد معدات مختبر مراقبة الجودة

يرجى من سيادتكم التكرم بتقديم عرض سعر لتوريد المعدات المبينة في الجدول المرفق بهذا الكتاب، وذلك وفق الشروط التالية:

١. أن يتضمن العرض السعر الإفرادي والسعر الإجمالي بالدرهم المغربي، مع بيان مدة الصلاحية.

٢. أن تكون مدة التسليم في موعد أقصاه ٤٥ يوماً من تاريخ إرسال طلب الشراء.

٣. أن يشمل العرض التركيب والتشغيل والتدريب لفائدة ٣ تقنيين على الأقل.

٤. أن تكون مدة الضمان سنتين على الأقل، وأن يتضمن العرض عقد صيانة سنوي بعد انتهاء الضمان.

٥. أن يرفق العرض بشهادة المطابقة للمواصفات الأوروبية CE، وبشهادة المنشأ.

٦. أن يتضمن العرض كتالوجات تقنية باللغة الفرنسية أو العربية.

٧. أن يكون العرض ساري المفعول لمدة ٩٠ يوماً على الأقل من تاريخ فتح المظاريف.

٨. أن يتضمن العرض شروط الدفع المقترحة، مع العلم أن الدفع يتم على ثلاث دفعات.

٩. أن يتضمن العرض قائمة بقطع الغيار الموصى بها لسنتين من التشغيل.

١٠. أن يتضمن العرض اسم وعنوان وهاتف وبريد إلكتروني للشخص المكلف بالمتابعة.

١١. أن يتضمن العرض شهادة التأهيل المسبق سارية المفعول.

١٢. أن يتضمن العرض تعهداً بعدم التعاقد من الباطن دون موافقة كتابية مسبقة.

١٣. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالمواصفات الفنية المطلوبة دون أي تعديل.

١٤. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالسرية التامة بشأن المعلومات المتبادلة.

١٥. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالقوانين واللوائح المعمول بها في المملكة.

١٦. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالمواعيد المحددة في هذا الكتاب.

١٧. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط العامة والخاصة لهذا الطلب.

١٨. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة التأخير.

١٩. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة الإخلال.

٢٠. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة الفسخ.

٢١. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة القوة القاهرة.

٢٢. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة التنازل.

٢٣. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة الحجز.

٢٤. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة الإفلاس.

٢٥. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة التصفية.

٢٦. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة الاندماج.

٢٧. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة التحويل.

٢٨. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة التغيير.

٢٩. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة التعديل.

٣٠. أن يتضمن العرض تعهداً بالالتزام بالشروط الجزائية في حالة الإلغاء.

المدير العام

عبد الرحمن بن يوسف الشرقاوي

1725010017

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр Дугаар А/45 Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгож,
Ёс зүйн дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоол, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Ёс зүйн дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Ёс зүйн дүрмийг нийт ажилтнуудад танилцуулан, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо (Ц.Гүрбадам)-нд үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарснаар Газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн "Тушаал хүчингүй болгож, дүрэм шинэчлэн батлах тухай" А/69 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

1725010177

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 01 дүгээр сарын 22-ны
өдрийн А/45 дугаар тушаалын хавсралт

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилго нь газрын хэмжээнд ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журмыг хэрэгжүүлэхдээ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журмыг баримтална.

1.3.Энэ дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл эс үйлдэхүйг ёс зүйн зөрчил гэнэ.

1.4.Энэхүү ёс зүйн дүрэм нь Хөдөлмөрийн “дотоод журам”-ын салшгүй хэсэг байна.

Хоёр.Ажилтны баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээ

2.1.Ажилтан нь албан үүргээ гүйцэтгэхдээ дор дурдсан зарчмыг баримтлан ажиллана:

2.1.1.хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

2.1.2.хүнлэг, энэрэнгүй, шударга ёсыг дээдлэх;

2.1.3.мэргэжлийн нэр хүнд, үнэ цэнийг хамгаалах;

2.1.4.ёс суртахууны үлгэр дууриалалтай байх;

2.1.5.хуулийг чанд сахих, хариуцлагатай байх;

2.1.6.аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх, тэгш байдлыг хангах;

2.1.7.хараат бус байж гадны нөлөөнд автахгүй байх;

2.1.8.захирах, захирагдах ёсыг сахин биелүүлэх;

2.1.9.манлайлах, хамтач байх;

2.2.Ажилтан нь албан үүргээ гүйцэтгэхдээ дээр дурдсан зарчмын хүрээнд дараах Ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх үүрэгтэй:

2.2.1.иргэн, хуулийн этгээдийн асуудал, өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэн хариу өгч, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх;

2.2.2.иргэн, хуулийн этгээдээс хууль тогтоомжид заагаагүй нэмэлт баримт бичиг, төрийн цахим мэдээллийн санд байгаа, эсхүл төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр солилцон ашиглах боломжтой баримт бичгийг цаасан хэлбэрээр шаардахгүй байх;

2.2.3. ажлын байр, олон нийтийн газар, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа болон цахим орчин, нийгмийн сүлжээнд зүй бус үг хэрэглэхгүй, үйлдэл, зан байдал гаргахгүй байх;

2.2.4.хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичиг, төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, түүний хэрэгжилтийн талаарх эх сурвалжгүй, үндэслэлгүй мэдээ, мэдээлэл хийх, тараахгүй байх;

2.2.5.үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний эрх болон иргэн, хуулийн этгээдийн нэр төрийг хүндэтгэх, тэдэнд учирч болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьчилан сэргийлэх;

2.2.6.албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн хүний хувийн болон эмзэг мэдээлэл, төрийн болон албаны нууцын тухай хуулиар хамгаалагдсан нууцыг хадгалах, хамгаалах;

2.2.7.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, Газрын хэмжээнд мөрдөгдөж байгаа соёл, дэг журам, дүрэм, зааврыг чанд баримтлан, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх;

2.2.8.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлаас татгалзах, хамаарал бүхий этгээдийн ашиг сонирхолтой холбогдох аливаа шийдвэр гаргахгүй байх;

2.2.9.албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдэд хууль бусаар давуу байдал олгохгүй байх, тэднээс бэлэг, хөнгөлөлттэй зээл, үйлчилгээ, бусад хангамж, ашигтай нөхцөл бүхий саналыг хүлээж авахгүй байх;

2.2.10.хууль тогтоомж зөрчсөн, авлига авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдлийн талаарх мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдээлэх;

2.2.11.өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээл, түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр эрх бүхий байгууллагад хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлэх;

2.2.12.төрийн байгууллага, албан тушаалын болон албан тушаалтны нэрийг өөрт ашигтай байдал бий болгох зорилгоор ашиглахгүй байх;

2.2.13.албан хаагчийг ажил үүргээ гүйцэтгэхэд хууль бусаар нөлөөлөх, саад учруулах, хөндлөнгөөс оролцох, хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардахгүй байх;

2.2.14.газрын эд хөрөнгө, техник хэрэгсэл, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх, эд хөрөнгө, техник хэрэгслийг стандарт болон ашиглалтын горимын дагуу зөв, гамтай, цэвэр нямбай ашиглах;

2.2.15.албаны хэрэгцээнд ашиглаж байгаа "хөх" өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай автотээврийн хэрэгслийг хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх;

2.2.16.албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс бусад олон нийтийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцохдоо шударга, ёс зүйтэй хандах;

2.2.17.албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд бүрэн хариуцаж гүйцэтгэх, өөрийн гаргасан ажил мэргэжлийн алдаа, дутагдал, ёс зүйн зөрчлийг шударгаар

хүлээн зөвшөөрөх, үйлдэлдээ дүгнэлт хийж бусдаас уучлалт гуйх, зохих хариуцлага хүлээх чадвартай байх;

2.2.18.хувийн үзэл бодлоос үл хамааран төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, шийдвэр болон бусад эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөх;

2.2.19.төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцохгүй байх;

2.2.20.хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, нийгмийн сүлжээнд төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаатай холбоотой зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх, эх сурвалж нь тодорхой бус мэдээ, мэдээллийг өгөхгүй байх;

2.2.21.албан үүргээ гүйцэтгэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, улс төрийн болон хувийн үзэл бодол, эрүүл мэндийн байдал, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь ялгаварлан гадуурхахгүй байх, эрхийг нь аливаа хэлбэрээр хязгаарлахгүй байх;

2.2.22.албан үүргээ гүйцэтгэхдээ хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, хөрөнгө, орлого болон бусад байдлаар ялгавартай хандаж, шийдвэр гаргахгүй байх;

2.2.23.албан тушаалын бүрэн эрхээ ашиглан бусдад үг, үйлдэл, цахимаар болон бусад хэлбэрээр хүнд суртал, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэхгүй байх;

2.2.24.бусдыг аливаа хэлбэрээр дарамталж хууль бус үйлдэл хийхэд хүргэхгүй байх;

2.2.25.албан харилцаанд нүүрний хувирал, биеийн хэлэмж, үг хэллэг, бусад байдлаар бусдыг үл тоомсорлох, тохуурхан даажигнах, дорд үзэх зэрэг харилцаа, хандлага гаргахгүй байх;

2.2.26.газрын хөдөлмөрийн "дотоод журам"-д заасан хэм хэмжээг чанд баримтлах;

2.2.27.харилцаа, хандлага, хувцаслалт, биеэ авч явах байдал, ажлын арга барил, үг, үйлдлээрээ бусдад зөв үлгэрлэн, манлайлах;

2.2.28.албан үүргээ гүйцэтгэхдээ байгууллагаас зөвшөөрсөн албаны цахим шуудан ашиглах, албан харилцаанд хувийн цахим шуудан ашиглахгүй байх;

2.2.29.албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үг, үйлдэл гаргахгүй, мөрийтэй тоглоом (казино) тоглох, энэ төрлийн үйлчилгээний газраар үйлчлүүлэхгүй байх;

2.2.30.ажлын байранд болон ажлын цагаар бооцоотой мөрийтэй тоглоом тоглох, ийм төрлийн үйл ажиллагааны зохион байгуулалтад оролцохгүй байх;

2.2.31.Албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэж, олон нийтийн газарт мөрдөх дэг журмыг сахих;

2.2.32.удирдах албан тушаалтныг хууль нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах;

2.2.33.удирдах албан тушаалтны үзэл бодолд нийцэх эсэхийг үл харгалзан аливаа дүгнэлт, шийдвэрийн үр дагавар, эрсдэл, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх;

2.2.34.хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх, саналын зөрүүтэй тохиолдолд бусдын үзэл бодол, итгэл үнэмшил, мэргэшсэн байдалд хүндэтгэлтэй хандах, зөрчилдөөнийг шударга, эв зүйгээр шийдвэрлэхэд манлайлал үзүүлэх;

2.2.35.хувийн үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэхдээ бусдын үзэл бодол, итгэл үнэмшлийг хүндэтгэж тэдэнд учирч болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх;

2.2.36.албан харилцаанд зүй бус үг хэллэг, үйлдэл, зан байдал гаргахгүй байх, хамт олны эв нэгдэлд сөргөөр нөлөөлөх зүйлд бусдыг уриалахгүй, турхирахгүй байх;

2.2.37.хамт олны мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ажлын гүйцэтгэлийг шударга, бодитой үнэлэх;

2.2.38.өөрийн мэдлэг, ур чадвар, туршлага, ажил хэргийн мэдээ, мэдээлэл, зөвлөгөөг хамтран ажилладаг албан хаагчидтай хуваалцах;

2.2.39.удирдах, удирдуулах зарчмыг баримталж, удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтнаас баталсан шийдвэр, хууль ёсны үүрэг даалгавар, шаардлагыг цаг тухайд нь мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх;

2.2.40.албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахыг цээрлэх;

Гурав.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх

3.1.Ажилтны ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

3.2.Ёс зүйн зөрчил, шийдвэрлэлийн талаар Газрын мэдээллийн самбарт мэдээлэл байршуулан ажилтнуудад тухай бүр хүргэх;

3.3.Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх;

3.4.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг ханган ажиллах;

3.5.Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал, нэмэгдэл хөлс олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзах;

3.6.Ажилтнуудыгёс зүйн чиглэлээр мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх;

Дөрөв.Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

4.1.Ёс зүйн дүрмийг зөрчиж, ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон ажилтанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан ёс зүйн дараах хариуцлагын аль нэгийг хүлээлгэнэ.

4.1.1.гомдол гаргагчаас уучлалт гуйхыг үүрэг болгох;

4.1.2.өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;

4.1.3.газрын ажилтнуудын өмнө нээлттэй сануулах;

4.1.4.ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах;

4.2.Тухайн этгээд сайн дурааpаа албан тушаалаасаа чөлөөлөгдсөн нь ёс зүйн хариуцлага хүлээсэнд тооцогдоно.

4.3.Ажилтанд ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн нь хуульд заасны дагуу эрүүгийн, зөрчлийн, сахилгын хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

4.4.Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг зөрчил гаргасан ажилтанд танилцуулна.

4.5.Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

4.6.Ёс зүйн зөрчил илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гарснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүй.

4.7.Ажилтан ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол түүнийг ёс зүйн шийтгэлгүйд тооцно.

4.8.Ёс зүйн хорооны дүгнэлтээр тухайн ажилтан ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол түүнд албан ёсоор мэдэгдсэнээр сайн дурааpаа хариуцлага хүлээх боломж олгоно.

4.9.Ажилтан дараах хэлбэрээр ёс зүйн хариуцлагыг сайн дурааpаа хүлээж болно. Үүнд:

4.9.1.хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас уучлалт гуйх;

4.9.2.ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх;

4.10.Ажилтан ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо уг шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гаргаж болно.

Тав.Ёс зүйн зөрчлийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, шийдвэрлэх

5.1.Ажилтан ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэл, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн болон, Газрын дотоод хяналтаар илэрсэн зөрчил, баримт нь Ёс зүйн дэд хороогоор авч хэлэлцэх үндэслэл болно.

5.2.Ёс зүйн зөрчлийг Газрын Ёс зүйн дэд хороо шалгана.

5.3.Ёс зүйн зөрчлийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 3-5 өдрийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол эрх бүхий албан тушаалтны тогтоосон хугацаанд зөрчилд холбогдсон ажилтнаас бичгээр, эсхүл цахим шуудангаар тайлбар авах, шаардлагатай тохиолдолд тухайн ажилтнаас биечлэн тодруулга мэдээлэл авна

5.4.Шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагчаас нэмэлт тайлбар, тодруулга, бусад холбогдох ажилтнаас мэдээ, баримтыг гаргуулан авах

5.5.Шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулах

5.6.Цугларсан мэдээ, баримтад дүн шинжилгээ хийх

5.7.Ажилтан ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг тогтоон, дүгнэлт гаргах, үндэслэлийг тусгах

5.8.Дүгнэлтийг биечлэн гардуулснаар дараах этгээдэд мэдэгдсэнд тооцно. Үүнд:

5.8.1.гомдол мэдээлэл гаргасан этгээд;

5.8.2.зөрчилд холбогдсон ажилтан;

5.8.3.томилох эрх бүхий албан тушаалтан, байгууллага;

5.9.Ёс зүйн зөрчлийг шалгаж, шийдвэрлэхдээ хууль, тогтоомжид заасан ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.10.Зөрчлийг хянан шалгах ажиллагааны явцад тухайн асуудал нь гэмт хэргийн, зөрчлийн, сахилгын шинжтэй бол гомдол, мэдээллийг холбогдох материалын хамт зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлнэ.

5.11.Гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх бөгөөд нэмэлт шалгалт хийх шаардлагатай бол 14 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

5.12.Иргэний гомдол, мэдээлэл гаргахтай холбоотой харилцааг Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу зохицуулна.

5.13.Энэ дүрмийн 5.7-д заасан дүгнэлтийг эс зөвшөөрвөл гомдол, мэдээлэл гаргасан этгээд түүнд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор харьяалах дээд шатны газар гомдол гаргаж болно.

Зургаа:Томилох эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх

6.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.

6.2.Газрын хэмжээнд гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх,шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, зөрчлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээг авах.

6.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12.1.3-т тусгаснаар сар бүр олгож болно.

6.4.Энэ дүрмийн 5.7-д заасан дүгнэлтэд үндэслэж, зөрчил гаргасан этгээдэд зөрчлийн шинж байдалд нийцүүлэн хуульд өөрөөр заагаагүй бол ёс зүйн хариуцлага хүлээлгэх

6.5.Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулах

Долоо.Ёс зүйн дэд хороо

7.1.Газар нь Ёс зүйн дэд хороотой байна.

7.2.Ёс зүйн дэд хороо (цаашид "дэд хороо" гэх) нь бие даасан, хараат бус зарчмаар ажиллана.

7.3.Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Дэд хорооны шийдвэр дүгнэлт хэлбэртэй байна. Шийдвэрт хуралдааныг даргалагч, оролцсон гишүүд, нарийн бичгийн дарга гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

7.4.Дэд хорооны бүрэлдэхүүнийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сонгож, Газрын даргын тушаалаар баталгаажуулна.

7.5.Дэд хороо ажилтны ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй. Үүнд:

7.5.1.ажилтны ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;

7.5.2. Энэ дүрмийн 5.7-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

7.5.3.хэлтсүүдэд ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх;

7.5.4.хэлтсүүдэд гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах;

7.5.5.Ажилтны ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гарган холбогдох байгууллагад хүргүүлэх;

7.5.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

7.5.7.гишүүнээр ажилласны төлөө урамшуулал авах;

7.5.8.хуралдааны үед үүрэгт ажлаас түр чөлөөлөгдөх;

7.5.9.шийдвэрийн улмаас бусдын дарамт, шахалтад өртөхөөс хамгаалуулах;

7.5.10.ёс зүйн хариуцлага хүлээсэн этгээдийн шийдвэрийн талаарх бүртгэл хөтлөх, тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлэх.

----oOo----

«ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠰᠣᠶᠣᠯ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠶᠠᠮᠠᠨ»

ᠳᠡᠭᠡᠳᠦ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠶᠠᠮᠠᠨ ᠤ ᠰᠠᠶᠢᠳ ᠵᠠᠰᠤᠭ ᠤᠨ ᠭᠡᠷᠴᠢᠯᠭᠡᠭᠡ ᠪᠠᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠵᠠᠭᠪᠤᠷ

ᠬᠡᠯᠡᠪᠦᠷᠢ ᠤᠨ

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 29 өдөр Дугаар А/44 Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгож, журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын "Даргын зөвлөлийн ажиллах журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Ц.Гүрбадам)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарснаар Газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/36 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний
өдрийн А/147 дугаар тушаалын хавсралт

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (цаашид “газар” гэх)-ын даргын дэргэд Даргын зөвлөл (цаашид “зөвлөл” гэх) ажиллана. Зөвлөл нь даргад зөвлөх, энэхүү журамд заагдсан асуудлаар шийдвэр гаргахад туслах, холбогдох зохион байгуулалт бүхий үйл ажиллагааг зохицуулахад журмын зорилго оршино.

1.2.Зөвлөл нь үйл ажиллагаагаа хурал хэлбэрээр зохион байгуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

1.3.Зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд цахим хэлбэрээр оролцож болох бөгөөд тухайн гишүүнийг хуралдаанд оролцсоноор тооцно.

1.4.Зөвлөлийн дарга нь Газрын дарга, гишүүд нь Ерөнхий инженер, Хууль, дотоод хяналтын хэлтсийн дарга, Захиргааны хэлтсийн дарга, Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга нар, нарийн бичгийн дарга нь Хүний нөөцийн мэргэжилтэн *(холбогдох мэргэжилтэн)* байх бөгөөд үндсэн бүрэлдэхүүнд орохгүй, саналын эрхгүй байна.

1.5.Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй тохиолдолд Газрын даргад урьдчилан мэдэгдэж чөлөө авна.

Хоёр.Зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудлууд, түүнтэй холбогдох бэлтгэл хангах

2.1.Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын саналыг хэлтсүүд Захиргааны хэлтсийн даргад гаргана. Санал Захиргааны хэлтсээс зөвлөлийн нарийн бичгийн даргаар дамжин газрын даргад танилцуулагдана.

2.2.Зөвлөлийн гишүүд хуралд оролцохын өмнө нарийн бичгийн даргаас хүргүүлсэн хэлэлцэх асуудлын баримттай танилцсан байна.

2.3.Зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

2.3.1.Цалин нэмэх, бууруулах

2.3.2.Албан хаагчдын нийгмийн асуудал, хөнгөлөлт, дэмжлэг тусламж үзүүлэх

2.3.3.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан *(улирал бүр)*

2.3.4.Газрын хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайлан

2.3.4.Бусад шаардлагатай асуудлууд

2.4.Зөвлөлийн хурлын байрны нөхцөл, техник хэрэгсэл (хэлэлцэж буй асуудалтай холбогдох биет үзүүлэн, зураг загвар, орчин үеийн техник хэрэгсэл зэрэг)-ийн бэлэн байдлыг нарийн бичгийн дарга хангуулна.

2.5.Хэлэлцэх асуудлын хүрээнд холбогдох материалыг хурал болохоос 2 хоногийн өмнө гишүүдэд урьдчилан хүргүүлэх, хурал эхлэх цаг, хугацааг мэдэгдэх зэрэг хурлын бэлтгэл хангах ажлыг нарийн бичгийн дарга хариуцсан гүйцэтгэнэ.

2.6.Газрын даргад урьдчилан танилцуулаагүй асуудлыг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхгүй.

2.7.Нарийн бичгийн дарга нь хэлэлцүүлэхээр ирүүлсэн материалыг шаардлага хангаагүй тохиолдолд буцаах эрхтэй.

2.8.Яаралтай хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатай асуудал гарвал Газрын даргын зөвшөөрснөөр хэлэлцэж болно.

Гурав:Зөвлөлийн хурлын дэг

3.1.Хурлыг зөвлөлийн дарга, түүний эзгүйд эрх олгосон албан тушаалтан удирдах ба гишүүд хурал эхлэхээс 10 минутын өмнө суудлаа эзэлсэн байна.

3.2.Зөвлөлийн гишүүдийн 70 хувиас дээш хувь нь ирсэн тохиолдолд ирцийг хүчинтэйд тооцно.

3.3.Зөвлөлийн хурал даргалагч хурлын ирц, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж хурлыг эхлүүлнэ. Зөвлөлийн дарга шаардлагатай бол хэлэлцэх асуудалтай холбоотой өргөдөл гаргасан ажилтныг хуралд оролцуулж болно.

3.4.Зөвлөлийн хурал нь хэлэлцэх асуудлын танилцуулга, асуулт, хариулт, санал хэлэх, дүгнэлт гаргах гэсэн дараалалтай байх ба санал хэлэх хугацаа 5 минут байна.

3.5.Зөвлөлийн гишүүд хэлэлцэж буй асуудлаар санал хэлсний дараа зөвлөлийн дарга тухайн асуудлаар санал хураах ба асуудлыг шийдвэрлэхдээ хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналд үндэслэнэ. Санал тэнцсэн тохиолдолд зөвлөлийн даргын санал давуу эрхтэй.

3.6.Зөвлөлийн дарга хэлэлцэж буй асуудлын талаар гарсан саналыг нэгтгэн дүгнэж, хуралд оролцогчдод уншиж сонсгоно.

3.7.Зөвлөлийн хурлаас хэлэлцсэн асуудлын талаар тэмдэглэл, холбогдох газрын даргын тушаал гарна.

3.8.Зөвлөлийн гишүүд хэлэлцүүлсэн асуудал, үзэл бодлыг хүндэтгэж, ажил хэрэгч санал шүүмж, албан ёсны байр суурийг илэрхийлнэ.

3.9.Зөвлөлийн гишүүн нь үг хэлэх, тайлбар хийхдээ бүдүүлэг үг, хэллэг хэрэглэх, бусдын яриаг таслах, хувийн шинжтэй үндэслэл гаргах, өөрийн саналыг дэмжүүлэхээр бусдыг албадах, шахалт үзүүлэх, нөлөөлөхийг хориглоно.

Дөрөв:Зөвлөлийн гишүүний эрх, үүрэг, хариуцлага

4.1.Зөвлөлийн гишүүд даргад зөвхөн зөвлөх үүрэг хүлээнэ.

4.2.Хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллээр хангагдах, нэмэлт тайлбар авах.

4.3.Хурлаар хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцах

4.4.Хэлэлцэгдсэн асуудал, авсан арга хэмжээ, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах

4.5.Зөвлөлийн гишүүд нь хуралд оролцохдоо энэ журам болон Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг сахин биелүүлнэ.

4.5.Төрийн болон байгууллагын, хувь хүний нууцыг чандлан хамгаалах

4.6.Зөвлөлийн гишүүд энэхүү журмыг зөрчсөн гэж үзвэл ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Тав.Зөвлөлийн хурлын нарийн бичгийн даргын үүрэг

5.1.Хурлын тов зарлах, хурал зохион байгуулах тов өөрчлөгдсөн тохиолдолд гишүүдэд урьдчилан мэдэгдэх

5.2.Шаардлагатай тохиолдолд хэлэлцэх асуудалтай холбогдох материалыг хурал болохоос ажлын нэг хоногийн өмнө Зөвлөлийн гишүүдэд хүргүүлэх

5.3.Зөвлөлийн хурлын тэмдэглэл (*нэгдсэн дугаар олгох, холбогдох ажиллагаа хийх*)-ийг нарийн бичгийн дарга *(холбогдох мэргэжилтэн Хүний нөөцийн мэргэжилтэнд хүргүүлнэ)* холбогдох стандартын дагуу хөтөлж, ажлын нэг өдрийн дотор албажуулна.

5.4.Хурлын тэмдэглэл нь гаргасан санал, хэлсэн үгний утга агуулга, найруулгыг гажуудуулаагүй байна.

5.5.Хурлын тэмдэглэлд хуралд оролцсон нийт бүрэлдэхүүн гарын үсэг зурж баталгаажуулна.

5.6.Хурлын тэмдэглэлийг хуралд оролцоогүй зөвлөлийн гишүүнд танилцуулна.

5.7.Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга нэгтгэн гаргаж, Захиргааны хэлтэс хяналт тавьж ажиллана.

5.8.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлын тэмдэглэл болон холбогдох бусад баримт бичгийг албан хэрэг хөтлөлт, архивын зохих журмын дагуу бүрдүүлж, дараа оны эхний улиралд багтаан газрын архивд хүлээлгэн өгнө.

----oOo----

«ᠥᠪᠥᠷ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠪᠤᠰᠤᠯᠠᠭᠴᠢ ᠬᠣᠰᠢᠭᠤ»
ᠬᠤᠪᠢᠶᠠᠨ ᠬᠠᠪᠴᠠᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠬᠤᠪᠢᠷᠠᠯᠳᠠᠨ

ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠳᠠ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠡᠭᠡᠨ ᠤ ᠭᠡᠷᠴᠢᠯᠭᠡᠯ ᠤᠨ ᠬᠡᠯᠬᠢᠴᠡ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ

НИЙСЛЭЛИЙН
“ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 29 өдөр Дугаар А/48 Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгож, зөвлөл
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны “Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай” А/72 дугаар тушаал, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 9.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-т Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачилгыг дэмжих замаар залуучуудын үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тэдгээрийн эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах зорилготой Залуучуудын хөгжлийн зөвлөлийг шинэчлэн байгуулсугай.

2.Залуучуудын хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

3.Зөвлөлийн үйл ажиллагааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийн хүрээнд зохион байгуулж, жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж, холбогдох зөвлөмж, зөвлөгөө, мэдээллийг нийт ажилтнуудад хүргэж ажиллахыг Залуучуудын хөгжлийн зөвлөлийн тэргүүн (Э.Батжаргал)-д даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Ц.Гүрбадам)-т даалгасугай.

5.Энэ тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн “Залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулах тухай” А/15 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx 172501009

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний
өдрийн А/48 дугаар тушаалын хавсралт

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Тэргүүн:	Э.Батжаргал	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Хууль, дотоод хяналтын хэлтсийн Дотоод хяналтын мэргэжилтэн;
Дэд тэргүүн:	Г.Буянжаргал	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Барилгын хяналтын инженер;
Гишүүд:	Д.Оюунбилэг	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн Системийн мэргэжилтэн;
	Г.Энхжин	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Ногоон байгууламж хариуцсан хяналтын инженер;
	Д.Отгонтөгс	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Цахилгааны хяналтын инженер;
	Д.Солонго	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Зураг төслийн хяналтын хэлтсийн Зураг төслийн хяналтын инженер;
	Х.Данзан	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Төлөвлөлт судалгааны хэлтсийн Төлөвлөлт судалгааны мэргэжилтэн;
	Э.Элдэв-Очир	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Ус хангамж, ариутгах татуургын хяналтын инженер;
Нарийн бичгийн дарга:	Э.Ундрахмөрөн	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн Сургалт хөгжил, шагнал хариуцсан мэргэжилтэн.

1725010027

«ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠪᠠᠢᠴᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠤᠤᠯᠢ» ᠬᠡᠪᠯᠡᠯ ᠤᠨ ᠭᠠᠷᠴᠠᠭ

᠂᠐᠐᠐

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 04 өдөр Дугаар А/45 Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгож, Үнэлгээний
хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, мөн хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэг, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны А/337 дугаар захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/337 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Лхагважав)-д даалгасугай.

3.Төсөл, арга хэмжээний хүрээнд холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Энхчимэг)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга захиалагчийн хяналтын хэлтэс (Б.Ганзориг)-т даалгасугай.

5.Энэ тушаал гарснаар Газрын даргын 2026 оны А/29, мөн оны А/39 дүгээр тушаалуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

1725010111

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 05 дугаар сарын 04-ний
өдрийн А/45 дүгээр тушаалын хавсралт

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Б.Лхагважав	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Зураг төслийн хяналтын хэлтсийн дарга;
Гишүүд:	Б.Хүчитбаатар	НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын Гэрээ, эрх зүйн зохицуулалт, дүн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн;
	Л.Гансүх	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Төлөвлөлт судалгааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн;
	Я.Алтантунгалаг	"Инженер технологийн үндэсний төв" Төрийн бус байгууллагын ажилтан;
Нарийн бичгийн дарга:	Г.Энхчимэг	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Төлөвлөлт судалгааны хэлтсийн Төлөвлөлт судалгааны мэргэжилтэн.

1725010034

ظاهرة ٠٠ ٢٠٢٥/٠٩/٢٥ م

НИЙСЛЭЛИЙН
“ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 11 өдөр Дугаар А/50 Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгож, газрын Шуурхай хурал зохион байгуулах журам, бүрэлдэхүүн, загвар хүснэгт шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны “Журам батлах тухай” А/188 дугаар захирамж, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Шуурхай хурал зохион байгуулах журам”-ыг нэгдүгээр, “Шуурхай хурлын бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар, “Шуурхай хурлаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт тайлагнах загвар хүснэгт”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Газрын шуурхай хурлаар хэлэлцэж буй асуудлаар шийдвэр гаргахад идэвхтэй оролцож, түүний биелэлтэд хяналт тавин ажиллахыг хэлтсийн дарга нарт даалгасугай.

3.Энэхүү тушаалыг гарсан өдрөөс мөрдөж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Ц.Гүрбадам)-т даалгасугай.

4.Энэхүү тушаал гарснаар 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр батлагдсан А/73 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

1725010115

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 05 дугаар сарын 11-ний
өдрийн А/50 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

"НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН ШУУРХАЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ (цаашид "газар" гэх)-ын Шуурхай хурал (цаашид "хурал" гэх)-ыг газар, хэлтсийн тухайн жилийн зорилтыг тодорхойлох, нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх, цаг үеийн тулгамдсан ажлын явц, үр дүнгийн талаар хэлэлцэх, өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах,хэлтэс хоорондын уялдаа холбоог сайжруулахад чиглэсэн дотоод шуурхай мэдээлэл солилцох зэрэг асуудлыг Газрын дарга, Ерөнхий инженер, хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэй зохион байгуулах харилцааг зохицуулна.

1.2.Хурал нь холбогдох хууль, дүрэм, журмыг дээдлэн асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, цөөнхийн саналыг хүндэтгэн сонсож, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг удирдлага болгоно.

1.3.Хурлын нарийн бичгийн даргаар Захиргааны хэлтсийн мэргэжилтэн ажиллана.

1.4.Хурлыг тодорхой сэдвээр төрөлжүүлэн зохион байгуулж болох ба Газрын дарга ээлжит бус хурал зарлан хуралдуулж болно.

Хоёр.Хурлын бэлтгэл хангах

2.1.Хурлын зохион байгуулалт, бэлтгэл хангах ажлыг Захиргааны хэлтсийн мэргэжилтэн *(хуралд саналын эрхгүй оролцоно)* хариуцна.

2.2.Хурлаар хэлэлцэх асуудлыг Захиргааны хэлтэс, бусад хэлтсээс урьдчилан авч, хурлын даргад танилцуулна.

2.3.Хурлаар хэлэлцэх асуудал, үүрэг, даалгаврын хэрэгжилтийг Захиргааны хэлтсийн дотоод сүлжээ (шейр)-нд "Газрын шуурхай" хавтаст байршуулсан байна.

2.4.Хэлтсийн дарга нар нь шинээр хэлэлцүүлэх асуудалтай урьдчилан танилцаж, санал дүгнэлтээ бэлтгэж хуралд ирнэ.

2.5.Хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг Захиргааны хэлтсийн дарга тухайн хуралд танилцуулна.

Гурав:Хурал

3.1.Хурлыг 14 хоногт 1-2 удаа зохион байгуулна. Хурлын товлогдсон хугацаанд өөрчлөлт орж *(газрын дарга хурлын товыг өөрчлөн зарлаж болно)* болох бөгөөд нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнтэй уялдуулан зохион байгуулж болно.

3.2.Хурлын ирцийг Захиргааны хэлтсийн дарга бүртгэж, хурал даргалагчид танилцуулна.

3.3.Хурлын эхэнд өмнөх хурлын үүрэг, даалгаврын биелэлтийг хариуцсан гишүүн танилцуулж болно.

3.4.Зайлшгүй хэлэлцэж шийдвэрлэх асуудал гарвал хурал даргалагчийн зөвшөөрснөөр хэлэлцэх асуудлын дараалалд нэмж оруулж болно.

3.5.Гишүүд хурал зарласан хугацаанд хүрэлцэн ирэх үүрэгтэй. Хуралд хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцох боломжгүй гишүүн хурлын даргаас чөлөө авсан үед түүнийг орлон ажиллах ахлах инженер, ахлах мэргэжилтнийг оролцуулна.

3.6.Хурлыг нийт гишүүдийн олонх оролцсоноор хүчинтэйд тооцно. Хуралд гишүүд таслах *(батлах)* эрхтэй оролцоно.

3.7.Хурлыг Газрын дарга даргалж удирдан явуулна. Газрын даргын эзгүйд *(өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралт)* түүний үүрэг болгосон албан тушаалтан буюу гишүүн хурлыг удирдана.

3.8.Хурлын шийдвэрт санал тэнцсэн тохиолдолд хурлын даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Хурлыг шаардлагатай тохиолдолд цахим хэлбэрээр явуулж болно.

Дөрөв:Хурлын дэг

4.1.Хурал нь асуудал бүрт танилцуулга, асуулт, хариулт, санал шүүмжлэл, шийдвэр гаргах гэсэн дараалалтай байна.

4.2.Хуралд хэлэлцүүлж буй асуудлыг боловсруулсан хэлтэс, ажлын хэсгийн дарга танилцуулж, даргалагчийн зөвшөөрснөөр асуулт, хариулт эхэлнэ.

4.3.Гишүүдийн асуулт болон санал, оролцогчдын хариулт нь хэлэлцэж буй асуудалтай шууд холбоотой, товч тодорхой байх бөгөөд нэг гишүүний үг хэлэх хугацаа 3 минутаас хэтрэхгүй байна.

4.4.Хурал даргалагч зөвшөөрөл өгөөгүй байхад үг хэлэх буюу асуулт тавих, энэхүү эрхээ эдлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, басамжлах, яриаг нь таслах, өмнөөс нь үг хэлэх зэрэг ёс зүйд үл нийцэх үйлдэл гаргахыг хориглоно.

4.5.Хурал даргалагч хурлыг дүгнэж, дараагийн хурал хүртэл хийж гүйцэтгэх ажлын талаар үүрэг, даалгавар өгч шуурхай хурлыг хаана. Хуралд оролцож амжаагүй гишүүнд хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийг тухай бүр танилцуулна.

4.6.Шаардлагатай тохиолдолд хурлын үеэр хурал даргалагчаас өгсөн үүрэг, даалгавар, түүний биелэлтийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг Мэдээллийг технологийн хэлтэс, Захиргааны хэлтэстэй хамтран зохион байгуулж болно.

4.7.Хурлын тэмдэглэл *(гишүүдийн гаргасан санал, хэлсэн үгний утга агуулга, найруулгыг гажуудуулаагүй байна)*-ийг Захиргааны хэлтсийн мэргэжилтэн холбогдох стандартын дагуу хөтөлж, ажлын нэг өдрийн дотор танилцуулж, гарын үсгээр баталгаажуулна.

4.8.Баталгаажсан хурлын тэмдэглэлийн хүрээнд хурал даргалагчаас өгсөн үүрэг даалгаврыг цаасан суурьтай холбогдох хэлтсүүдэд хүргүүлэх ажлыг Захиргааны хэлтсийн мэргэжилтэн зохион байгуулна.

4.9.Хурал даргалагч буюу хэлтсийн дарга (ахлах инженер, ахлах мэргэжилтэн) дараа өдрийн дотор хэлтсийн шуурхай хурлыг зарлан хуралдуулж, хурлаас өгсөн үүрэг даалгаврыг холбогдох инженер, мэргэжилтэнд танилцуулан үүрэгжүүлж, хэрэгжилтийг хангана.

4.10.Хурлын тэмдэглэл *(хэлтсийн хурлын тэмдэглэлд мөн хамаарна)*-ийг албажуулан ажиллах Захиргааны хэлтсийн мэргэжилтэн нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартын дагуу бүрдэл ханган, баталгаажуулах, хурлын тэмдэглэлийн хавсралтаар хуралдсан хуралдааны гэрэл зургийг өнгөтөөр хэвлэн баримт бичгийн стандартын бүрдлийн дагуу байрлуулан хавсаргах, файл үүсгэн "JPEG", "PNG" өргөтгөлтэйгээр хуралдааны дугааруар хадгалах, мөн войс хийж файл үүсгэн хадгалахдаа "mp3" өргөтгөлтэйгээр 256 kbps нягтралаар хадгалж, дараа оны 1 дүгээр улиралд багтаан газрын архивын ажилтанд бүртгэлээр хүлээлгэн өгнө.

4.11.Хурлын гишүүд Газрын Ёс зүйн дүрэм, Хөдөлмөрийн "дотоод журам"-ыг чанд, сахин мөрдөнө.

Тав.Шийдвэрийг баталгаажуулах, биелэлтэд хяналт тавих

5.1.Хурлын шийдвэр нь "тэмдэглэл" байна.

5.2.Хурлын тэмдэглэлийг Захиргааны хэлтсийн мэргэжилтэн хөтөлнө.

5.3.Хурлын тэмдэглэлд хурлын дарга, гишүүд, тэмдэглэл хөтөлсөн мэргэжилтэн нар гарын үсэг зурж баталгаажуулан цаасан суурьтай албажуулна.

5.4.Хурал даргалагч нь шийдвэрлэх шаардлагатай асуудлаар хариуцах эзэн, гүйцэтгэх хугацааг тодорхой зааж үүрэг даалгавар өгнө.

5.5.Хурлаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт, үр дүнг энэ журмын хавсралтаар батлагдсан загвар хүснэгтийн дагуу тайлагнаж, нотлох баримтын хамт тогтоосон хугацаанд дээд газарт хүргүүлэх ажлыг Захиргааны хэлтсийн мэргэжилтэн гүйцэтгэж Захиргааны хэлтсийн дарга хяналт тавьж ажиллана.

5.6.Хурлын үеэр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнг шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж танилцан зураг, дүрс бичлэгээр баталгаажуулан танилцуулж болно.

5.7.Хурлын үед гар утсаар ярих, хурал даргалагчийн зөвшөөрөлгүйгээр орж, гарахыг хориглоно.

Зургаа.Хурлын дэг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

6.1.Хуралд оролцогчид дэг зөрчсөн бол хурал даргалагч дараах хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:

6.1.1.сануулах;

6.1.2.хурлаас гаргах;

6.2.Шуурхай хурлыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 ба түүнээс дээш удаа тасалсан, хурлаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй, хурлын явцад ёс зүйн зөрчил гаргасан гишүүнд Газрын Ёс зүйн дүрэм болон Хөдөлмөрийн "дотоод журам"-д заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

----oOo----

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 05 дугаар сарын 11-ний
өдрийн А/150 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ШУУРХАЙ ХУРЛЫН БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:	ГАЗРЫН ДАРГА
ГИШҮҮД:	ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
	ХУУЛЬ, ДОТООД ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
	ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА
	САНХҮҮ, АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
	БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
	ЗУРАГ ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
	ТӨЛӨВЛӨЛТ СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА
	МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:	ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 05 дугаар сарын 11-ний
өдрийн А/30 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ

20... ОНЫ ... ДУГААР САРЫН ...-НИЙ ӨДРИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН ШУУРХАЙ ХУРЛААС ӨГСӨН
ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ЗАГВАР ХҮСНЭГТ

20 ... оны ... дүгээр сарын ...

Улаанбаатар хот

№	Үүрэг, даалгаврын нэр	Хэлтэс	Хэрэгжилт	Үр дүн	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжээгүй шалтгаан
1	2	3	4	5	6	7
Дундаж хувь						

ТАНИЛЦСАН:

.... (.....)
(албан тушаал) (гарын үсэг) (огноо)
тамга, тэмдэг

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

.... (.....)
(албан тушаал) (гарын үсэг) (огноо)
хэлтсийн дарга,
ахлах инженер,
ахлах мэргэжилтэн

ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН:

.... (.....)
(албан тушаал) (гарын үсэг) (огноо)

د افغانستان اسلامي امارت
د کورنيو چارو وزارت

د ولسوالۍ چارو رياست

ګڼه: ۱۲۹۶ نېټه: ۱۴۰۳/۰۶/۲۰

د ولسوالۍ چارو رياست ته
د ولسوالۍ چارو رياست
د ولسوالۍ چارو رياست

موضوع: د ولسوالۍ چارو رياست د ولسوالۍ چارو رياست د ولسوالۍ چارو رياست

НИЙСЛЭЛИЙН
“ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 18 өдөр Дугаар А/51 Улаанбаатар хот

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн үр дүнг хагас жил, жилийн эцсийн байдлаар нэгтгэн тайлагнаж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Ц.Гүрбадам)-т даалгасугай.

ДАРГА Б.МӨНХБАТ

G:\2026 оны Албан бланк\tushaal.docx 1725010123

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 05 дугаар сарын 18-ны
өдрийн А/51 дүгээр тушаалын хавсралт

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа	Зардал	Хамтран хэрэгжүүлэх
1	2	3	4	5	6	7
Нэг.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогын хүрээнд:						
1.1.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах биелэлтийг холбогдох газарт хүргүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангагдсан байна	II улирал	-	Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
1.2.	Албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын судалгаа гаргах, холбогдох газарт хүргүүлэх	Албан хаагчдын тоо, хувь	Албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын судалгаа бэлэн болно	IV улирал	-	Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Хоёр.Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох, жендэрийн тэгш байдлыг хангах ажлын хүрээнд:						
2.1.	Жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх мэдээлэл бэлтгэн хүргэх	Албан хаагчдын тоо, хувь	Албан хаагчид жендэрийн талаарх мэдлэг ойлголттой болно.	II-IV улирал	-	Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

1	2	3	4	5	6	7
2.2.	"Харилцан хүндэтгэе" аяныг газрын хэмжээнд зохион байгуулах	Арга хэмжээний тоо	Аян зохион байгуулагдсан байна	I-II улирал	Гүйцэтгэлээр	Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
2.3.	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны зохион байгуулах	Арга хэмжээний тоо	Аян зохион байгуулагдсан байна	II-VI улирал	-	Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
Гурав.Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын хүрээнд:						
3.1.	Хүүхэд асрах чөлөө авсан, бага насны хүүхэдтэй албан хаагчид уян хатан ажлын цагаар болон цахимаар ажиллах нөхцөл боломж бүрүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	Ажилчдын ажиллах тогтвор суурьшил сайжирна	VI улирал	-	Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Дөрөв.Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын хүрээнд:						
4.1.	Эхнэр нь амаржсан ажилтанд ажлын 10 өдрийн цалинтай чөлөө олгож, бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	Ажилчдын ажиллах тогтвор суурьшил сайжирна	VI улирал	-	Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн

----oOo----

«ᠪᠦᠰᠦᠨ ᠤᠨ ᠠᠪᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠰᠤᠷᠭᠤᠭᠤᠯᠢ»

ᠪᠦᠰᠦᠨ ᠤᠨ ᠠᠪᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠰᠤᠷᠭᠤᠯᠢ

ᠬᠢᠴᠢᠶᠡᠯᠡᠭᠴᠢ ᠵᠢᠨ ᠨᠡᠷᠡ

ᠪᠠᠭᠰᠢ ᠵᠢᠨ ᠨᠡᠷᠡ

ᠪᠠᠭᠰᠢ ᠵᠢᠨ ᠨᠡᠷᠡ

ᠪᠦᠰᠦᠨ ᠤᠨ ᠠᠪᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠰᠤᠷᠭᠤᠭᠤᠯᠢ ᠤᠨ ᠵᠠᠭᠪᠤᠷ ᠵᠢᠨ ᠳᠤᠭᠠᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠤᠨ ᠵᠠᠭᠪᠤᠷ ᠵᠢᠨ ᠵᠢᠷᠤᠭ ᠳᠤ ᠵᠢᠭᠠᠰᠤᠨ

НИЙСЛЭЛИЙН
“ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 28 өдөр Дугаар А/52 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны А/1338 дугаар захирамж, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 2025 оны ОН2412090017004 дугаартай ажлын гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1338 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан жагсаалтын 3 дугаар төсөл, арга хэмжээ Зоогийн газрын хооллох заалны тавилга, эд хогшил худалдан авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн архивын ажилтанд хүлээлгэн өгөхийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (П.Хорол-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, дотоод хяналтын хэлтэс (Б.Батбилэг)-т даалгасугай.

ДАРГА Б.ГАНЗОРИГ

1725010145
G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/62 дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Ц.Гүрбадам	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн дарга;
Гишүүд:	М.Хуанган	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын Инженерийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээний албаны Инженерийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээний албаны дарга;
	С.Цогтмаа	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын Үйлчилгээний албаны Хоол үйлдвэрлэл, зоогийн албаны дарга;
	Д.Оюун	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын Захиргаа төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Тооцооны нягтлан бодогч;
	Ю.Хүслэн	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын Захиргаа төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хууль эрх зүй-Тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн;
	А.Батцэнгэл	“Сан мед” ХХК-ийн Захирал;
	О.Ган-Өлзий	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн Архивын эрхлэгч;
Нарийн бичгийн дарга:	П.Хорол-Эрдэнэ	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Цахилгааны хяналтын инженер.

«ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠤᠲᠠᠨ ᠵᠡᠭᠦᠨ ᠳᠦᠭᠡᠷᠡᠭ ᠪᠤᠰᠤ ᠬᠡᠰᠡᠭ»

ᠬᠡᠯᠡᠰᠦᠯᠬᠡᠭᠴᠢ ᠵᠢᠨᠰᠢᠨ

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 28 өдөр Дугаар А/63 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны А/1792 дугаар захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 2026 оны ОН2612010052 дугаартай ажлын гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/1792 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан жагсаалтын 25 дугаарт заасан Сонгинохайрхан дүүрэгт байрлах 240 ортой цэцэрлэгийн барилга худалдан авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох ажилтанд хүлээлгэн өгөхийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Алтанбагана)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Ц.Гүрбадам)-т даалгасугай.

ДАРГА Б.ГАНЗОРИГ

1725010147

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 05 дугаар сарын 08-ны
өдрийн А/53 дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Б.Лхагважав	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Зураг төслийн хяналтын хэлтсийн дарга;
Гишүүд:	О.Жүгдэрнамжил	Нийслэлийн Архивын газрын төлөвлөлт, мэргэжлийн удирдлагын хэлтсийн Улсын байцаагч;
	Б.Гүнчин-Иш	Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Ахлах дэслэгч;
	Б.Эрдэнэболд	Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн Төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан Ахлах мэрэгжилтэн;
	Н.Энхбаяр	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Баруун бүсийн Ахлах инженер;
	Ч.Хоролгарав	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн;
	Б.Болорцэцэг	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Дулаан хангамж, агаар сэлгэлтийн хяналтын инженер;
	М.Батмягмар	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Цахилгааны хяналтын инженер;
	У.Одгэрэл	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Холбооны хяналтын инженер;
	Х.Орхонсэлэнгэ	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Барилгын хяналтын инженер;
Нарийн бичгийн дарга:	Б.Алтанбагана	"ТИ ДИ ЦИ ХОЛДИНГ" ХХК-н Захирал.

«ᠬᠥᠬᠡᠨᠲᠡᠭᠢᠨ ᠬᠣᠲᠠ ᠰᠤᠯᠢᠨᠭᠠ ᠪᠤᠰ ᠬᠣᠲᠠ»
ᠬᠥᠬᠡᠨᠲᠡᠭᠢᠨ ᠬᠣᠲᠠ ᠰᠤᠯᠢᠨᠭᠠ ᠪᠤᠰ ᠬᠣᠲᠠ ᠶᠡᠬᠡ ᠵᠠᠰᠠᠭ

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/55 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны А/356 дугаар захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэг, 2026 оны ОН2612010067002 Багц-2.3 дугаартай ажлын гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/356 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 2 дугаарт заасан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Гэмт хэрэг, гамшгаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн архивын ажилтанд хүлээлгэн өгөхийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Төмөрбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээллийн технологийн хэлтэс (С.Соёмбо)-т даалгасугай.

ДАРГА Б.ГАНЗОРИГ

1725010153
G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 05 дугаар сарын 29-ний
өдрийн А/55 дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Л.Гансүх	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Төлөвлөлт судалгааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн;
Гишүүд:	Б.Батаа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн;
	Ц.Ууганнаст	Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын алба Салбар зөвлөлийн гишүүн байгууллага, дүүрэг хариуцсан Ахлах ажилтан;
	Г.Сэр-Од	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн Техник хангамж хариуцсан мэргэжилтэн;
	О.Ган-Өлзий	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн Архивын эрхлэгч;
Нарийн бичгийн дарга:	Б.Төмөрбаатар	“Фэйд Трий” ХХК-ийн Захирал.

«ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠰᠢᠯᠢᠨ ᠵᠢᠨᠰᠢᠯᠡᠯ ᠤᠨ ᠬᠤᠤᠯᠢ ᠵᠦᠢᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠡᠭᠡᠨ ᠤ ᠭᠡᠷᠴᠢᠯᠭᠡᠭᠡ»

ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷᠠ ᠶᠢᠨ ᠡᠷᠡᠨ ᠳᠦ ᠪᠦᠷᠢᠳᠭᠡᠭᠳᠡᠪᠡ

ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷᠠ ᠶᠢᠨ ᠡᠷᠡᠨ ᠳᠦ ᠪᠦᠷᠢᠳᠭᠡᠭᠳᠡᠪᠡ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠰᠢᠯᠢᠨ ᠵᠢᠨᠰᠢᠯᠡᠯ ᠤᠨ ᠬᠤᠤᠯᠢ ᠵᠦᠢᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠡᠭᠡᠨ ᠤ ᠭᠡᠷᠴᠢᠯᠭᠡᠭᠡ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠠᠰᠤ ᠤᠨ ᠵᠢᠭᠠᠰᠤ ᠪᠤᠯᠤᠨ ᠵᠢᠭᠠᠰᠤ ᠤᠨ ᠬᠡᠰᠡᠭ

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/56 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны А/356 дугаар захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэг, 2026 оны ОН2612010067002 Багц-2.4 дугаартай ажлын гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/356 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 2 дугаарт заасан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Гэмт хэрэг, гамшгаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар батлуулсугай.

2.Холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн архивын ажилтанд хүлээлгэн өгөхийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (У.Эрдэнэбямба)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээллийн технологийн хэлтэс (С.Соёмбо)-т даалгасугай.

ДАРГА Б.ГАНЗОРИГ

1725010152

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 05 дугаар сарын 29-ний
өдрийн А/... дугаар тушаалын хавсралт

А/56

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Л.Гансүх	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Төлөвлөлт судалгааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн;
Гишүүд:	Б.Батаа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн;
	Ц.Ууганнаст	Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын алба Салбар зөвлөлийн гишүүн байгууллага, дүүрэг хариуцсан Ахлах ажилтан;
	Г.Сэр-Од	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн Техник хангамж хариуцсан мэргэжилтэн;
	О.Ган-Өлзий	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Захиргааны хэлтсийн Архивын эрхлэгч;
Нарийн бичгийн дарга:	У.Эрдэнэбямба	“Ай Ти Зон” ХХК-ийн гүйцэтгэх Захирал.

«ᠪᠦᠭᠦᠳᠡ ᠨᠠᠢᠷᠠᠮᠳᠠᠬᠤ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ»

ᠪᠦᠭᠦᠳᠡ ᠨᠠᠢᠷᠠᠮᠳᠠᠬᠤ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠲᠥᠷᠥ

ᠬᠡᠪᠯᠡᠯ

ᠵᠠᠷᠯᠢᠭ ᠤᠨ ᠬᠡᠯᠬᠢᠴᠡ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠤᠨ ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠰᠠᠶᠢᠳ ᠲᠥᠷᠥᠭᠡᠳᠦᠯ ᠤᠨ ᠠᠵᠢᠯ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠤᠨ ᠵᠠᠭᠪᠤᠷ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠤᠤᠯᠢ ᠵᠦᠢᠯ ᠤᠨ ᠵᠢᠷᠤᠭ ᠤᠨ ᠵᠢᠷᠤᠭ ᠳᠤᠭᠠᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠤᠨ ᠵᠢᠷᠤᠭ ᠳᠤᠭᠠᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠤᠨ ᠲᠠᠪᠤᠨ ᠳᠤᠭᠠᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠳᠡᠪᠲᠡᠷ ᠤᠨ ᠪᠦᠯᠦᠭ ᠤᠨ ᠲᠠᠪᠤᠨ ᠳᠤᠭᠠᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠤᠨ ᠲᠠᠪᠤᠨ ᠳᠤᠭᠠᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠤᠨ ᠵᠢᠷᠤᠭ

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/57 Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.2 дахь хэсэг, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн үр дүнг хагас жил, жилийн эцсийн байдлаар нэгтгэн тайлагнаж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Ц.Гүрбадам)-т даалгасугай.

ДАРГА Б.ГАНЗОРИГ

1725010155

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 05 дугаар сарын 29-ний
өдрийн А/... дугаар тушаалын хавсралт

"НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хугацаа	Хамтран хэрэгжүүлэх
1	2	3	4	5	6
Нэг. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд					
1.1	"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль", Газрын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах	Журмын хэрэгжилт, хувь	100 хувь	I-IY улирал	Захиргааны хэлтэс
Хоёр.Ажлын байран дээрх эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж болох аюулуудыг тодорхойлж, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохион байгуулах ажлын хүрээнд					
2.1	Ажлын байран дээрх эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж болох аюулуудыг тодорхойлж, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохион байгуулах;	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	2 удаа, 100 хувь	III, IV улирал	Захиргааны хэлтэс
Гурав.Ажилтнуудын аюулгүй ажиллагааг сайжруулах зорилгоор сургалт (холбогдох мэргэжилтэнтэй хамтран), бусад холбогдох ажлыг тухай бүр зохион байгуулах ажлын хүрээнд					
3.1	Хяналтын инженерийн мэдлэг, мэргэшсэн байдлыг дээшлүүлэх чиглэлийн сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан инженерийн хувь,	1 удаа, 80-аас доошгүй хувийг хамруулах,	I-IY улирал	Захиргааны хэлтэс, Санхүү, аж ахуйн хэлтэс
3.2	Албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллах хандлага төлөвшүүлэх, гэнэтийн осол, хордлого, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс эрүүл мэндээ хамгаалах мэдлэг олгох чиглэлээр мэдээлэл хүргэх, сурталчилж ажиллах, сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо, хувь	Мэдээ мэдээлэл сард 4 удаа, сургалт 1 удаа	I-IY улирал	Захиргааны хэлтэс

1	2	3	4	5	6
Дөрөв.Удирдлагын дэмжлэгтэйгээр “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд					
4.1	Гүйцэтгэгч байгууллагад ХАБЭА-ын хууль, хэрэгжилтийг хангах ажлын шаардлага, албан бичиг хүргүүлэх	Албан бичиг хүргүүлсэн гүйцэтгэгч байгууллагын тоо, хувь	1 удаа, 100 хувь (Гүйцэтгэгч 100 байгууллагад хүргүүлнэ.)	I-IY улирал	Захиргааны хэлтэс, Барилга захиалагчийн хяналтын хэлтэс
Тав.Гүйцэтгэгч байгууллага болон албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, төслийн удирдлага, чанарын менежментийн олон улсын болон үндэсний стандарт, арга зүйн шаардлагыг сурталчлан таниулах ажлын хүрээнд					
5.1	“Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" 1988 оны 167 дугаар конвенцийн агуулгыг сурталчилж ажиллах	Хэрэгжилтийн тоо, хувь	Сард 4 удаа, 100 хувь	I-IY улирал	Захиргааны хэлтэс,
5.2	2.6.Барилга угсралтын үе шатны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS:ISO 21500 стандарт, Барилгын чанарын менежментийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах ажлын гүйцэтгэх;	Мэдээ, мэдээллийг дотоод сүлжээнд нийтлэн ажилласан байна.	Сард 4 удаа, 100 хувь	I-IY улирал	Захиргааны хэлтэс,

----oOo----

«ᠨᠡᠭᠡᠳᠦᠯ ᠤᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠭᠭᠦᠭᠰᠡᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠯᠠᠭ ᠤᠨ ᠬᠤᠪᠢ»

ᠬᠡᠪᠯᠡᠯ ᠤᠨ ᠳᠤᠭᠠᠷ

ᠳᠤᠭᠠᠷ ᠬᠡᠪᠯᠡᠯ ᠤᠨ ᠳᠤᠭᠠᠷ ᠬᠡᠪᠯᠡᠯ ᠤᠨ ᠳᠤᠭᠠᠷ

НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 02 өдөр Дугаар А/58 Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай" 238 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2026 оны "Маягт загвар батлах тухай" 87 дугаар тогтоол, мөн даргын 2026 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай" 143 дүгээр тогтоол, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2026 оны Улсын үзлэг, тооллогын комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн Улсын үзлэг, тооллого явуулах журмын хүрээнд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн дотор зохион байгуулахыг Тооллогын комисс (Д.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Ц.Гүрбадам)-т даалгасугай.

ДАРГА Б.ГАНЗОРИГ

1725010159

G:\2026 он\Албан бланк\tushaal.docx

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 06 дугаар сарын 02-ны
өдрийн А/.. дугаар тушаалын хавсралт

А/58

ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Д.Пүрэвжав	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга;
Гишүүд:	Л.Болорчулуун	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Хууль, дотоод хяналтын хэлтсийн Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
	Г.Сэр-Од	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн Техник хангамж хариуцсан мэргэжилтэн;
	С.Нямсүрэн	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн Нярав;
Нарийн Бичгийн дарга:	Ө.Эрдэнэчимэг	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн Тооцооны нягтлан бодогч.

1725010058

د ولسمشر دفتر

ښاغلي ..... وکیل

د ولسمشر د لیکښتونو څانګې مسؤل (د لیکښتونو)- ۰

د ۲۰۲۶ کال د ډسمبر د میاشتې ۲۵ مه نیټه د ولسمشر دفتر ته د ښاغلي ..... وکیل د ولسمشر د لیکښتونو څانګې مسؤل (د لیکښتونو)- ۰ د ولسمشر د لیکښتونو څانګې د مسؤل د ۲۰۲۶ کال د ډسمبر د میاشتې ۲۵ مه نیټه د ولسمشر دفتر ته د ښاغلي ..... وکیل د ولسمشر د لیکښتونو څانګې مسؤل (د لیکښتونو)- ۰ د ولسمشر د لیکښتونو څانګې د مسؤل د ۲۰۲۶ کال د ډسمبر د میاشتې ۲۵ مه نیټه د ولسمشر دفتر ته د ښاغلي ..... وکیل د ولسمشر د لیکښتونو څانګې مسؤل (د لیکښتونو)- ۰

د ولسمشر دفتر

«ئەدلىيە مىنىستىرلىكى قارمىقىدىكى ئەدلىيە تەتقىقات ئورنى»

ئەدلىيە مىنىستىرلىكى قارمىقىدىكى ئەدلىيە تەتقىقات ئورنى «ئەدلىيە مىنىستىرلىكى قارمىقىدىكى ئەدلىيە تەتقىقات ئورنى»

2025-يىل 9-ئاي 10-كۈن

ئەدلىيە مىنىستىرلىكى قارمىقىدىكى ئەدلىيە تەتقىقات ئورنى

«ᠬᠦᠮᠦᠨ ᠵᠢᠨ ᠬᠡᠪᠯᠡᠯ ᠦᠢᠯᠡᠳᠪᠦᠷᠢ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ»

ᠬᠦᠮᠦᠨ ᠵᠢᠨ ᠬᠡᠪᠯᠡᠯ ᠦᠢᠯᠡᠳᠪᠦᠷᠢ ᠤᠨ ᠵᠠᠭᠪᠤᠷ ᠵᠢᠨ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ